

Цэндийн Амгалантөгс¹, Лхагвадоржийн Дэлгэрмаа¹,
Дашзэвэгийн Базаргүр¹

¹Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн,
Монгол ул, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

Аргал ууланд малтан судалсан хиргисүүрийн судалгаа

Хураангуй. Энэхүү өгүүлэлд Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн нутаг дахь Аргал уулын хүрэл зэвсгийн үеийн дурсгалыг малтан судалсан урьдчилсан үр дүнгийн талаар танилцуулж байна. Эдгээр 9 дурсгалын 7 нь хиргисүүрийн соёлд хамаарах дурсгал, харин бусад нь он цагийн хувьд өөр цаг үед холбогдох юм. Малтан судалсан 10, 14, 15, 23-р дурсгалууд нь дөрвөлжин хүрээтэй хиргисүүр бол 11, 12, 13-р хиргисүүрүүд нь дугуй хүрээтэй юм. Хиргисүүр-буган хөшөөний соёлынхон НТӨ XIII-VIII зуун буюу 600 орчим жилийн хугацаанд оршин тогтнохдоо газар нутгийн хувьд хойд тал нь Өвөр Байгал, өмнөд тал нь Говь, зүүн тал нь Хэнтий нуруу, баруун тийш Алтай нуруу, цаашлаад Тэнгэр уул хүртэл асар уудам нутагт өөрсдийн булш, оршуулга, тахилын байгууламжийг бүтээн цогцлоосон байдаг. Тухайн бүс нутагт энэ үеийн дурсгалуудын малтлага судалгаа харьцангуй бага хийгдсэн байдаг ба энэ бүс нутагт эрт цагаас хүн тасралтгүй оршин амьдарч байсан, оршуулгын өвөрмөц зан үйл, олон соёлын үйл явц бүрэлдэн тогтсон болохыг харуулах судалгаа болсноороо эрдэм шинжилгээний хувьд чухал ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: хүрлийн үе, хиргисүүр, хүрээ, дагуул байгууламж, хадны зураг

Amgalantugs Tsend¹, Delgermaa Lkhagvadorj¹,
Bazargur Dashzeveg¹

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar 13330, Mongolia

Archaeological Investigation of Khirgisuur at Argal Mountain

Abstract. This article presents the preliminary results of the excavations of Bronze Age archaeological monuments located in the territory of Ögöömör bag, Lün soum of Töv province, specifically on Argal Mountain. Of the nine investigated monuments, seven belong to the khirgisuur cultural tradition, while the remaining features represent different chronological periods. Monuments Nos. 10, 14, 15, and 23 are khirgisuur structures with rectangular enclosures, whereas Monuments Nos. 11, 12, and 13 have circular enclosures. The Khirgisuur–deer Stone cultural horizon flourished for approximately 600 years, from the 13th to the 8th centuries BCE. Over this long duration, its creators constructed burial and ritual complexes across an expansive territory stretching from Trans-Baikal in the north to the Gobi Desert in the south, and from the Khentii Mountains in the east across the Altai Mountains to the Tian Shan in the west. Excavations of sites belonging to this period have been relatively limited in this region. Nevertheless, the present research demonstrates continuous human occupation since ancient times, reveals distinctive funerary practices, and provides evidence for complex cultural processes. Thus, the study holds significant scholarly value.

Keywords: bronze age, khirgisuur, frame, satellite structures, rock art

Удиртгал

Монголын хүрэл, түрүү төмрийн үеийн оршуулгын байгууламжууд нь холбогдох он цаг, газар зүйн байршил, гадаад, дотоод бүтэц зохион байгуулалт, олдвор хэрэглэгдэхүүн гэх мэт олон шинжээрээ археологийн 10 орчим бие даасан соёлд холбогдоно. Өнөөгийн Монгол орны нутаг, ОХУ-ын Тува, Буриадын нутаг Байгал нуурын өмнөд хэсэг, БНХАУ-ын Алтайн нурууны бүс нутаг, Шинжааны хязгаар зэрэг газарт өргөн тархсан хөгжингүй хүрлээс хожуу хүрлийн үед холбогдох томоохон дурсгалын нэг бол хиргисүүр юм. Хиргисүүр нь тухайн цогцолбор дурсгалт газартаа хамгийн багадаа нэгээс хэдэн зуу хүртэл тоотойгоор оршдог. Хиргисүүрийг байгуулахдаа ихэвчлэн түүнд ашиглах боломжтой хад чулуу ихтэй уул, хөндий, гол, нуурын чулуу ихтэй газарт байгуулсан нь байдаг боловч зарим тохиолдолд хад чулуу багатай газар нүсэр том хэмжээтэй хиргисүүрийг байгуулсан байдаг.

Хиргисүүр нь голдоо овгор чулуун дараастай, гадуураа дөрвөлжин болон дугуй хүрээтэй, хүрээний гадна талаар дагалдуулан байгуулсан ихэвчлэн цагариг болон битүү чулуун дараас бүхий дагуул тахилын байгууламжуудаас бүрдэнэ. Дагуул тахилын байгууламжууд нь нэгээс хэдэн зуу, мянга хүртэл тоотой байх бөгөөд тэдгээр нь угсаа гарал, ертөнцийг үзэх үзэл, сүсэг бишрэл, орон нутгийн ялгаа зэргийг тусгасан онцлогтой байдаг. Голын дараасны доор ихэнх тохиолдолд эртний газрын түвшинд хүнээ тавихдаа толгойг нь ихэвчлэн баруун зүгт хандуулан тэнэгэр байдлаар оршуулж, дээр нь том хавтгай чулуугаар хайрцаг буюу бунхан байгуулж, дээрээс том жижиг чулуугаар үелэн дарсан байдаг.

Энэхүү өгүүлэлд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн судалгааны анги 2025 онд Төв аймгийн Лүн сумын нутаг дахь “Аргал” нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд нийт 9 дурсгалын малтлага судалгааг хийж гүйцэтгэсэн талаар өгүүлнэ.

Судалгааны тойм. Төв аймгийн Лүн сумын нутаг дахь Аргал уулын Хоёр бөхөн хэмээх газарт 2009 онд МУИС-ийн Археологи-антропологи тэнхимийн багш У.Эрдэнэбатын удирдлагаар археологийн 1-р курсийн танилцах дадлагын хүрээнд хүрэл зэвсгийн үеийн 1 хиргисүүрийн дагуул байгууламж 2, Хүннү булш 2, он цаг тодорхойгүй 1 булшийг тус тус малтан судалсан ажээ (Эрдэнэбат, 2009).

2012 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Базаргүр, Ц.Амгалантөгс, Ц.Буянхишиг нар Төв аймгийн Лүн, Баянхангай сумын нутаг дахь “Булнай Түшиг” ХХК-ий хайгуулын лиценз бүхий “Тээг”

хэмээх талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэжээ. Хайгуулаар хүрлийн үеэс Монголын үеийг хүртэлх нүүдэлчдийн булш оршуулгын дурсгал 220 тоотой илрүүлэн баримтжуулсан байна (Гүнчинсүрэн нар, 2012, 70).

2016 онд археологич Я.Цэрэндагва, Р.Төрбат, С.Далантай нар Төв аймгийн Лүн сумын нутагт буй Элстэйн давааны хадны зургийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, хуулбар хийх, тухайн дурсгалын ойр орчмын археологийн дурсгалыг судлах, нутгийн ардын аман мэдээг шалгах зорилгоор археологийн хайгуул судалгааны явуулсны үр дүнд хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр 6, дөрвөлжин булш 13, дугуй булш 1, Хүннүгийн үеийн булш 26, эртний улсуудын үед холбогдох тахилын байгууламж 9, зэл чулуу 1 мөн Элстэйн давааны өвөрт 40 гаруй хүннү булштай томоохон дурсгалт газрыг тус тус илрүүлэн бүртгэжээ (Цэрэндагва нар, 2016).

2018 онд хооронд МУИС-ийн ШУС-ийн Антропологи, археологийн тэнхим, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, “Ибисоку” ХХК-ийн судлаачид хамтран Төв аймгийн Лүн сумын төвөөс баруун хойш 42 км зайд орших баруун урдаас зүүн хойш чиглэсэн Аргалын энгэр хэмээх үргэлжилсэн уулсын салбар Оорцог уул, Онгоцотын ам хэмээх газруудад археологийн малтлага судалгааг явуулахаар тус хээрийн шинжилгээний ангийн археологич З.Батсайхан, Ч.Амартүвшин, Д.Содномжамц, Б.Батдалай, Б.Батзориг нар ажиллаж Оорцог уулын зүүн энгэрт хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дагуул байгууламж 1, цагариг хэлбэрийн булш 1, дөрвөлжин булш 2 малтан судалсан бөгөөд тус уулын орчимд хийсэн хайгуул судалгааны үр дүнд хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр 16, дөрвөлжин булш 30, он цаг тодорхойгүй булш 7 нийт 53 дурсгалыг бүртгэн тэмдэглэж байжээ (Батсайхан нар, 2019).

2024 онд бидний малтан судалсан Төв аймгийн Өгөөмөр багийн нутаг дахь Аргал уул болон тухайн уулын ойр орчимд Монголын Үндэсний Музейн хээрийн судалгааны баг “Хан-Алтай ресурс” ХХК-ийн хүсэлтээр хайгуул судалгааны ажил явуулж тусгай зөвшөөрлийн 1647.68 га талбай болон түүний дам нөлөөллийн 2133.72 га талбайд археологийн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэн нийт 98 тооны археологийн дурсгалуудыг бүртгэн баримтжуулжээ (Бүрэнтөгс нар, 2024).

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн нутаг “Аргал” нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд нийт 9 дурсгал малтан судалсан. Малтан судалсан 9 дурсгалын 2 нь чулуун байгууламж, 7

нь хиргисүүр-буган хөшөөний соёлд холбогдох дурсгал бөгөөд эдгээрийн 10, 14, 15, 23-р дурсгалууд нь дөрвөлжин хүрээтэй хиргисүүр бол 11, 12, 13-р хиргисүүрүүд нь дугуй хүрээтэй ба энэхүү өгүүллийн үндсэн хэрэглэгдэхүүн болно. Төв аймгийн Лүн сумын нутагт хиргисүүр-буган чулуун хөшөөний соёлд холбогдох дурсгалын малтлага судалгаа бусад бүс нутгуудтай харьцуулахад маш цөөн хийгдсэнээрээ онцлог юм. Өнөөгийн Монгол нутагт 1990-2023 оны хооронд нийт 17 аймаг, 50 гаруй сум, 2 дүүргийн нутагт нийт 241 хиргисүүр малтан судалсан ба эдгээрээс дугуй хүрээтэй 57, дөрвөлжин хүрээтэй 58, хүрээгүй 11, үлдсэн 115 хиргисүүрийн хүрээний хэлбэр тодорхой бус байна (Амгалантөгс 2024, 152). Малтан судалсан хиргисүүрүүдийн гадаад болон дотоод бүтэц зохион байгуулалт, оршуулгын зан үйл, онцлог, холбогдох он цагийн хамаарал зэргийг дээр дурдсан Монгол орны бусад бүс нутгийн ижил дурсгалуудтай харьцуулан судлах арга зүйг ашиглалаа.


Малтлагын тодорхойлолт

Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн нутаг Аргал хэмээх уул нь сумын төвөөс баруун хойд зүгт 35 орчим км зайд Туул голын хойно оршдог.

Аргал уул нь далайн төвшнөөс дээш 1200 метрт байрлах ба зүүн урд талд Айраг уул, баруун урд нь Улаан толгой овоо хэмээх намхавтар уулнуудтай залгана. Уулын орой хэсгээр цайвар өнгийн хадан тогтцуудтай ба уулын хормой, бэл, жалга судаг дагасан аманд археологийн дурсгалууд тархан байрлана. Аргал уул болон түүний ойр орчмын уулууд нь буга, чоно, үнэг, хар сүүлт, гөрөөс гэх мэт ан амьтнаар баялгаас гадна түүх, соёлын арвин дурсгалуудтай.

Дурсгал-09 (Чулуун байгууламж). Уг дурсгал нь уурхайн олборлолт явуулах амны дунд хэсэгт үерийн улмаас тогтсон гүн жалганы баруун эргийн тэгш дэвсгэ дээр байрлана. Том хэмжээтэй цайвар өнгийн боржин чулуугаар зуван дугуй хэлбэртэй, төв хэсэгтээ цөөн чулуутай сийрэг дараас үйлдсэн. Зарим дараас чулуу газарт дутуу шигдсэн, сул бөгөөд ихэнх чулуунууд газарт шигджээ. Тус дурсгалыг хайгуул судалгааны хүрээнд “Дурсгал-09” хэмээн дугаарласан дугаарын дагуу тэмдэглэв. Хэмжээ нь өнгөн хөрсийг цэвэрлэсний дараах байдлаар 3.8 x 4.3 м.


Энэхүү дурсгалын дараас чулууг ил гарган бүрэн цэвэрлэж гэрэл зургаар баримтжуулалт



Дурсгалын байршлын зураг



Зураг 1. Дурсгал-09. Агаарын зураг



Зураг 2. Дурсгал-09. Дараасны гар зураг

хийж малтахад, цэвэрлэгээний явцад дурсгалын төв хэсэг болон баруун талын дараас чулуу газрын хөрсөнд гүн шигдсэн болох нь мэдэгдэнэ. Иймд хойноос урд зүгт чиглэсэн 2.3 м хөндлөн тэг татаж баруун талд зүсэлт хийж үзэхэд, малтлагын гүн 20 см болоход ямар нэгэн толбо болон булш хийсний шинж тэмдэг илэрсэнгүй. Малтлагын явцад зөөлөн элсэрхэг бор шаргал хөрсөн давхарга үргэлжилж байв. Тиймээс дахин 20 см гүнд малтлага судалгааг үргэлжлүүлэхэд малтлагын гүн 40 см болоход ямар нэгэн олдвор болон толбо илэрсэнгүй. Харин байгууламжийн төв хэсэгт цагаан саарал чулуурхаг байгалийн хөрсөн давхарга илэрсэн тул дурсгалын төв хэсэгт 30 x 30 см хүрзний сорил хийж доош шалгаж үзэхэд байгалийн хөрс үргэлжлэн гарсан тул нийт гүн 50 см болоход малтлагын ажлыг дуусгав. Энэхүү дурсгалыг хайгуулын явцад гадна шинжээр *монгол булш* хэмээн бүртгэн тэмдэглэсэн хэдий ч малтлага судалгааны үр дүн тухайн дурсгалыг ямар дурсгал болохыг эцэслэн тогтоодгийн дагуу бидний малтлага судалгааны үр дүнд уг дурсгалыг булш биш хүний гараар бүтсэн чулуун байгууламж болохыг тогтоосон.

Дурсгал-10 (Хиргисүүр). Уг хиргисүүр хадтай уулын баруун урд энгэрт, баг зэргийн налуу газар дээр байрлана. Хиргисүүр нь дөрвөлжин хүрээтэй, хүрээний дөрвөн буланд дунджаар 1.1 м хэмжээтэй чулуун байгууламжтай бөгөөд төв дараас байгууламжийн өндөр 60 см. Хүрээний хэмжээ 11.5 x 12.5 м, төв дараас байгууламжийн чулуунууд баруун урд тийш газрын налууг дагаж нуралт үүссэн ба төв дараас байгууламжийн голч 9.5 м байна. Энэхүү хиргисүүрийн зүүн болон зүүн урд талд 1.7-2.8 хүртэлх голчтой нийт 7 тооны битүү чулуун дараас бүхий дагуул байгууламж байна.

Мөн хиргисүүрийн зүүн урд талд 2 ш, баруун урд талд 1 ш нийт 3 тооны цагариг хэлбэрийн дагуул байгууламж байна.

Малтлага судалгааг явуулахдаа хиргисүүрийн төв дараасны голд 3 м x 4 м хэмжээтэй талбай сонгон малтахад хиргисүүрийн төв дараас чулуун доороос зүүнээс баруун тийш зэрэгцүүлэн тавьсан ойролцоогоор 1 м-50 см хүртэл голчтой, 3 ш том чулуу 50 см гүнээс илэрсэн нь тухайн оршуулгын таг чулуу бололтой. Эдгээр таг чулууг зайлуулж малтлага судалгааг үргэлжлүүлэн явуулахад зүүнээс баруун хойд зүгт чиглэсэн 2.6 м x 1.4 м хэмжээтэй чулуун хайрцаг буюу авс илэрсэн. Малтлагыг чулуун хайрцаг дотор явуулахад дээш тэнгэр байдлаар харуулан тавьсан хүний оршуулга илэрсэн. Уг хиргисүүрт хүнээ оршуулахдаа газрын эртний хөрсөн дээр том чулуунуудыг тойруулан хайрцаг буюу авс хийн дотор талд нь хүний толгойг баруун хойд зүгт хандуулан, дээш тэнгэр байдлаар тавьж баруун гарыг тохойгоор нь бага зэрэг нугалж, хоёр хөлийг шулуун жийлгэн тавьжээ. Хүний яс илэрсэн гүн 90 см. Оршуулгаас илэрсэн хүний зүүн гарын бугалгын яс баруун талын дунд чөмгөний ясны гадна, хажууд байрлах ба шуу, богтос зэрэг яснууд баруун талын ташаа буюу сүүжний ясны хажууд байна. Харин зүүн талын нарийн шилбэний яс хөдөлж баруун талын дунд чөмгөний гадна талд байрлаж байна. Мөн зүүн талын далны яс нас барагчийн зүүн талын ташаа буюу сүүжний хажууд зөөгдөж очжээ. Бусад яснууд анх тавьсан байрлалаараа буюу анатомийн байрлалдаа байгаа нь дээрх яснууд он цагийн явцад мэрэгч амьтдын хөлөөр зөөгдөж хөдөлсөн болох нь тодорхой байна.


Энэхүү хиргисүүрийн малтлага судалгааны явцад илэрсэн хүний яс нь хадгалалтын хувьд маш сайн бөгөөд анхан шатны судалгаагаар 45-55

орчим настай, эрэгтэй хүн хэмээн тодорхойлов. Малтлагаас хүний оршуулгаас өөр ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илрэлгүй, цайвар, шаргал

өнгийн байгалийн хөрс гарсан тул малтлага судалгааг дуусгасан.



Зураг 3. Дурсгал-10. Хиргисүүрийн агаарын зураг



Зураг 4. Дурсгал-10. Хиргисүүрийн дэвсгэр зураг



Зураг 5. Дурсгал-10. Хиргисүүрийн оршуулга


Дурсгал-11 (Хиргисүүр). Энэхүү хиргисүүр нь 10-р хиргисүүрээс урд зүгт 100 м орчим зайд 12-р хиргисүүртэй ойролцоо, хадтай уулын баруун урд энгэрт байрлана. Дурсгал нь гадна талдаа дугуй хэлбэрийн хүрээтэй, төвдөө овгор чулуун дараастай, гадна чулуун хүрээний голч 16.5 м, төв дараасны голч 11.5 м, дараас чулууны өндөр 80 см байна. Хиргисүүрийн дараас чулууны төв хэсэгт тоногдож хөндөгдсөн шинж байхгүй байна. Малтлагыг төв дараасны голд явуулахдаа дээд

хэсэгт буй жижиг чулуунуудыг сөхөж авахад 40 см орчим гүнээс зүүнээс баруун хойд зүгт цувуулан тавьсан ойролцоогоор 50-80 см хэмжээтэй 4 ш том чулуунууд илэрсэн нь оршуулгын чулуун хайрцгийн таг чулуунууд болох нь тодорхой байв.


Дээр илэрсэн 4 ш таг чулууг авахад 2.2 м x 1.4 м хэмжээтэй чулуун хайрцаг илэрсэн. Малтлага судалгааг чулуун хайрцаг дотор явуулахад маш сайн хадгалагдсан хүний оршуулга 75 см гүнээс илрэв. Уг хиргисүүрт хүнээ оршуулахдаа толгойг

нь баруун хойд зүгт хандуулж, хүний нүүрийг хойд зүг харуулж, их биеийг дээш харуулж, хоёр гарыг тохойгоор нь үл ялиг нугалж, хоёр хөлийг зэрэгцүүлэн жийлгэн тавьжээ. Хүний 1-2 ш хавирга, хөл болон гарын үений яснууд, зүүн талын шууны яс гэх мэт цөөн тооны жижиг яснууд мэрэгч амьтдын хөлөөр зөөгдөн анхны байрлалаасаа хөдөлсөн байх ба бусад яснууд


анатомийн байрлалдаа байгаа нь тухайн дурсгал тоногдоогүйг илтгэнэ. Малтлага судалгааны явцад илэрсэн хүний яс нь хадгалалтын хувьд маш сайн ба анхан шатны судалгаагаар 20-30 орчим настай, эрэгтэй хүн хэмээн тодорхойлов. Малтлагаас хүний оршуулгаас өөр ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илрэлгүй, цайвар, шаргал өнгийн байгалийн хөрс гарсан тул малтлага судалгааг дуусгав.




Зураг 6. Дурсгал-11. Хиргисүүрийн дэвсгэр гар зураг



Зураг 7. Дурсгал-11. Хиргисүүрийн таг чулуу




Зураг 8. Дурсгал-11. Хиргисүүрийн оршуулга




Зураг 9. Дурсгал-11. Хиргисүүрийн оршуулга

Дурсгал-12 (Хиргисүүр). Хиргисүүр нь 11-р хиргисүүрээс урд зүгт 10 гаруй м зайд хадтай уулын баруун урд энгэрт байрлана. Дурсгал нь гадна талдаа дугуй хэлбэрийн хүрээтэй, төвдөө овгор чулуун дараастай, гадна чулуун хүрээний голч 16.5 м, төв дараасны голч 8.5 м, дараас чулууны өндөр 60 см байна. Малтлагыг төв дараасны голд явуулахдаа дээд хэсэгт буй жижиг чулуунуудыг сөхөж авахад 45 см орчим гүнээс зүүнээс баруун хойд зүгт цувуулан тавьсан ойролцоогоор 50-80 см хэмжээтэй 3 ш том чулуу илэрсэн нь оршуулгын чулуун хайрцгийн таг чулуунууд байв.

Дээр илэрсэн 3 ш таг чулууг авахад 2.1 м x 1.3 м хэмжээтэй чулуун хайрцаг илэрсэн. Малтлага судалгааг чулуун хайрцаг дотор явуулахад оршуулгын хөл тал буюу зүүн урд хэсгээс хүний гавлын ясны 2 ш хагархай 55 см гүнээс илрэв. Уг хиргисүүр нь эрт үед тоногдож хүний яснуудыг гаргаж хаясан бөгөөд зөвхөн гавлын ясны хагархай хэсгүүд үлдсэн байна. Оршуулгын чулуун хайрцгийн чиглэлийг харахад хүнээ оршуулахдаа толгойг нь баруун хойд зүгт хандуулсан болох нь малтлага судалгаанаас харж болно. Малтлагаас өөр ямар нэгэн олдвор илрээгүй болно.



Зураг 10. Дурсгал-12. Хиргисүүрийн дэвсгэр зураг




Зураг 11. Дурсгал-12. Хиргисүүрийн ориуулга


Дурсгал-13 (Хиргисүүр). Энэхүү хиргисүүр нь 12-р хиргисүүрээс урд зүгт 150 м гаруй зайд хадтай уулын баруун урд энгэрт байрлана. Дурсгал нь гадна талдаа дугуй хэлбэрийн хүрээтэй хүрээ нь зарим газраараа хэд хэдэн жижиг чулууг зэрэгцүүлэн 50 см орчим өргөнтэй хийсэн, зарим газраараа том чулуугаар нэг эгнээ цувуулан хийсэн байна. Мөн уг хиргисүүрийн хүрээний дөрвөн талд 2 м-4 м хүртэл голчтой дугуй хэлбэрийн чулуун байгууламжтай. Хиргисүүрийн хүрээний голч 26 м, төв дараасны голч 14.2 м, дараас чулууны өндөр 60 см байна. Малтлагыг төв дараасны голд явуулахдаа дээд хэсэгт буй жижиг чулуунуудыг сөхөж авахад 50 см гүнээс зүүнээс баруун хойд зүгт чиглэсэн 2.3 м x 1.3 м хэмжээтэй чулуун хайрцаг илэрсэн.

Малтлага судалгааг чулуун хайрцаг дотор


явуулахад маш сайн хадгалагдсан хүний оршуулга 80 см гүнээс илрэв. Уг хиргисүүрт хүнээ оршуулахдаа толгойг нь баруун хойд зүгт хандуулж, толгой, их биеийг дээш харуулж, хоёр гарыг их биеийг дагуулан, хоёр хөлийг зэрэгцүүлэн жийлгэн тавьжээ. Хүний цөөн тооны жижиг яснууд мэрэгч амьтдын хөлөөр зөөгдөн анхны байрлалаасаа хөдөлсөн байх ба бусад яснууд анатомийн байрлалдаа байгаа нь тухайн дурсгал тоногдоогүйг илтгэнэ. Малтлагын явцад илэрсэн хүний яс нь хадгалалтын хувьд маш сайн ба анхан шатны судалгаагаар 25-35 орчим настай, эрэгтэй хүн хэмээн тодорхойлов. Малтлагаас хүний оршуулгаас өөр ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илрэлгүй, цайвар, шаргал өнгийн байгалийн хөрс гарсан тул малтлага судалгааг дуусгав.



Зураг 12. Дурсгал-13. Хиргисүүрийн дэвсгэр гар зураг



Зураг 13. Дурсгал-13. Хиргисүүрийн таг чулуу



Зураг 14. Дурсгал-13. Хиргисүүрийн оршуулга


Дурсгал-14 (Хиргисүүр). Энэхүү хиргисүүр нь хадтай уулын баруун урд энгэрт байрлана. Хиргисүүрийн баруун талын хүрээг дайруулан айлын өвсний хашаа байна. Дурсгал нь гадна талдаа дөрвөлжин хэлбэрийн хүрээтэй, төвдөө овгор чулуун дараастай, хүрээний хэмжээ тэгш хэмтэй хэдий ч бүх талдаа харилцан адилгүй ба хамгийн их талдаа 14.5 м х 16.5 м хэмжээтэй, төв дараасны голч 10.8 м, дараас чулууны өндөр 60 см байна. Хиргисүүрийн дараас чулууны төв хэсэгт том чулуунуудтай бөгөөд дараасыг цэвэрлэх явцад дараас чулууны завсраас мал, амьтны ясны хэсгүүд гарч байлаа.

Хиргисүүрийн төв дараасны чулуунууд нэлээд эмх замбараагүй болсон байгаа нь уг дурсгал эрт үед тоногдсон бололтой. Малтлагыг төв дараасны голд явуулахдаа дээд хэсэгт буй чулуунуудыг авахад 30 см гүнээс зүүн урдаас баруун хойд зүгт


чиглэлтэй 2.5 м х 1.5 м хэмжээтэй чулуун хайрцаг илэрсэн. Малтлага судалгааг чулуун хайрцаг дотор явуулахад хайрцгийн зүүн урд хэсэг буюу оршуулгын хөл талаас хүний гавлын яс илэрсэн бол оршуулгын дунд хэсгээс олон тооны хүний ясны үлдэгдэл, хагархай хэсгүүд гарч байв. Уг хиргисүүр нь эрт үед тоногдож хүний яснууд эмх цэгцгүй болсон ба ихэнх яснууд үгүй болжээ. Хүний оршуулга 60 см гүнээс илрэв. Уг хиргисүүрийн чулуун хайрцгийн чиглэлийг харвал хүнээ баруун хойд зүгт хандуулан оршуулсан байна. Малтлага судалгааны явцад илэрсэн хүний яс нь хадгалалтын хувьд муу бөгөөд анхан шатны судалгаагаар 35-45 орчим настай, эрэгтэй хүн хэмээн тодорхойлов. Малтлагаас хүний оршуулгаас өөр ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илрэлгүй, цайвар, шаргал өнгийн байгалийн хөрс гарсан тул малтлага судалгааг зогсоосон.



Зураг 15. Дурсгал-14. Хиргисүүрийн агаарын зураг



Зураг 16. Дурсгал-14. Хиргисүүрийн дэвсгэр зураг



Зураг 17. Дурсгал-14. Хиргисүүрийн оршуулга

Дурсгал-15 (Хиргисүүр). Уг хиргисүүр нь 14-р дурсгалын урд 20 орчим метр зайд том том чулуутай сайрын баруун эргийн тэгш дэнж дээр байрлана. Дурсгал нь гадна талдаа дөрвөлжин хэлбэрийн хүрээтэй, хүрээний талуудын хэмжээ харилцан адилгүй ба хойд талын хүрээний хэмжээ 18.5 м, урд тал 20.7 м, баруун тал 15 м, зүүн талын хүрээ 16 м хэмжээтэй байна. Мөн хүрээний дөрвөн буланд чулуун байгууламжтай бөгөөд зүүн хойд талын чулуун байгууламжийн хэмжээ 2.4 м, зүүн урд тал 3 м, баруун урд тал 2.8 м, баруун хойд талын булангийн чулуун байгууламжийн хэмжээ 3 м. Хиргисүүрийн урд талд дунджаар 3.2 м голчтой битүү чулуун дараастай тахилын байгууламж 10 ш, урд болон хойд талдаа дунджаар 0,8-1 м голчтой цагариг хэлбэрийн дагуул байгууламж 24 ш байна.

Бид битүү чулуун дараастай тахлын байгууламжуудыг малтан судлахад адууны толгойн ясны үлдэгдлүүд илэрсэн. Харин цагариг хэлбэрийн тахилын байгууламжаас ямар нэгэн олдвор илрээгүй болно. Төв овгор чулуун дараас


нь гол хэсэгтээ 80 см өндөр, голч 14.5 м бөгөөд хүрээ болон дараасыг байгуулахдаа ойролцоо байрлах уулын том том чулууг ашиглаж хийжээ. Хиргисүүрийн дараасыг цэвэрлэх явцад төв хэсгээс цэвэрлэх явцад хиргисүүрийн төв хэсгээс нэлээд том хавтан чулуу илэрсэн бөгөөд уг хавтан чулууг авахад түүний доод хэсгээс хадны зураг илэрсэн. Мөн дараас чулууны завсраас мал, амьтны ясны хэсгүүд гарч байв. Хиргисүүрийн төв дараасны чулуунууд нэлээд эмх замбараагүй болсон байгаа нь уг дурсгал эрт үед тоногдсон бололтой. Малтлагыг төв дараасны голд явуулахдаа дээд хэсэгт буй чулуунуудыг авахад 45 см гүнээс зүүн урдаас баруун хойд зүгт чиглэлтэй 2.3 м х 1.8 м хэмжээтэй чулуун хайрцаг гарав. Малтлага судалгааг чулуун хайрцаг дотор явуулахад ямар нэгэн хүн малын яс илрээгүй. Уг хиргисүүр эрт үед тоногдож хүний оршуулга нь үгүй болжээ. Малтлагын нийт гүн 75 см. Чулуун хайрцгийн чиглэлийг харвал хүнээ баруун хойд зүгт хандуулан оршуулсан бололтой.




Зураг 18. Дурсгал-15. Хадны зураг



Зураг 19. Дурсгал-15. Хиргисүүрийн агаарын зураг



Зураг 20. Дурсгал-15. Хиргисүүрийн дэвсгэр зураг



Зураг 21. Дурсгал-15. Хиргисүүрийн ориуулга

Дурсгал-22 (Чулуун байгууламж). Энэхүү дурсгал нь өмнө малтсан 7 дурсгалаас нэлээд зайтай зүүн тийш 1.7 км орой хэсгээрээ багавтар хадтай уулын урд энгэрт тэгш газарт байрлана. Гадна бүтцийн хувьд зууван дугуй хэлбэртэй. Хойд талаараа дугуй хүрээ юм уу хашлага байсан бололтой том чулуунууд байна. Дурсгалын дараас баруун хойд талаараа бараг байхгүй ба төв хэсэгтээ цөөн тооны том чулууг газрын хөрснөөс үл ялиг овойлгон хийж, бусад хэсэгт жижиг чулууг нэгэн жигд дэвсэж хийжээ. Малтлага судалгааг дурсгалын төв хэсэг явуулахад малтлагын гүн 50 см болоход ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илрэлгүй цайвар шаргал өнгийн жижиг чулуутай байгалийн хөрс гарсан тул малтлага судалгааг дуусгасан.

Дурсгал-23 (Хиргисүүр). 22-р дурсгалаас зүүн хойд зүгт 500 м зайд айлын өвөлжөөний урд байрлана. Уг дурсгал нь гадна талдаа дөрвөлжин хэлбэрийн хүрээтэй, хүрээний талуудын хэмжээ харилцан адилгүй ба хойд талын хүрээний хэмжээ 14.5 м, урд тал 17.7 м, баруун тал 15.5 м, зүүн талын хүрээ 14 м хэмжээтэй байна. Мөн хүрээний дөрвөн

буланд чулуун байгууламжтай бөгөөд зүүн хойд талын чулуун байгууламжийн хэмжээ 2.2 м, зүүн урд тал 1.9 м, баруун урд тал 2.2 м, баруун хойд талын булангийн чулуун байгууламжийн хэмжээ 2 м. Төв дараасны голч 11 м. Өндөр 80 см. Хиргисүүрийн урд талд хүрээний гадна дунджаар 2.5-3 м голчтой нийт 10 тооны битүү чулуун дараастай тахилын чулуун байгууламжтай. Энэхүү хиргисүүрийн төв дараас голдоо хотойж хонхойж, дараас чулуунууд төв хэсэгтээ маш их эмх цэгцгүй болсон байх агаад энэ нь эрт үед тоногдож сүйрсэн нь тодорхой харагдаж байна. Малтлага судалгааг хиргисүүрийн төв дараасны гол хэсэгт явуулахад дээр өгүүлсэнчлэн булшны таг бололтой хавтгай чулуунуудыг тал бүр тийш тараан хаясан болох нь малтлагын явцад ажиглагдаж байв. Иймд бид малтлагыг цааш үргэлжлүүлэн сайтар шалгаж үзэхэд ямар нэгэн олдвор болон хүн, малын яс илрээгүй болно.

Хэлэлцүүлэг

Бидний малтан судалсан нийт 9 дурсгалыг дотор нь ангилбал: 09, 22 дугаар дурсгалыг хэдийгээр хайгуул судалгааны ажлын хүрээнд монгол булш, хүрлийн үеийн булш хэмээн тэмдэглэсэн байсан хэдий ч малтлага судалгаагаар хүний гараар бүтсэн тахил тайлгын зориулалттай чулуун байгууламж болох нь тодорхой болсон. Харин бусад дурсгалууд нь хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр-буган чулуун хөшөөний соёлд холбогдох дурсгалууд болох нь тодорхой байв. Малтан судалсан нийт 7 хиргисүүрээс хүний оршуулга илэрсэн бөгөөд эдгээрийн 10, 11, 13-р дурсгалууд нь тоногдож, сүйтгэгдээгүй, илэрсэн хүний ясны хадгалалт маш сайн бараг бүтнээрээ байсан бол 12, 14, 15, 23-р дурсгалууд нь их бага хэмжээгээр тоногдож хүний ясны ихэнх хэсэг үгүй болжээ.

Малтан судалсан дурсгалуудын 10, 11, 12, 13-р дурсгалууд нь дугуй хүрээтэй бөгөөд эдгээр дурсгалтай ижил дурсгалын малтлага судалгааг 2004 онд Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутаг Улаанбоомын 18-р хиргисүүр, 2008 онд Монгол-Америкийн хамтарсан төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Сөртгийн хөндийн 52-р хиргисүүр, Нам дөрөлжийн 43-р хиргисүүр (Амгалантөгс нар, 2008), 2015 онд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Мухдагийн амны 1-р хиргисүүр (Амартүвшин нар, 2015), 2017 онд Монгол-Америкийн хамтарсан төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын Их Хүнгүйн амны 1-р хиргисүүр, Адгийн голын 2-р хиргисүүр (Амгалантөгс нар, 2017:9), 2018 онд Монгол-Хятадын хамтарсан хээрийн шинжилгээний анги Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг Цагаан туруутын голын сав дагуу байрлах Онцын үзүүрийн 1-р хиргисүүр (Амгалантөгс нар, 2020), Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 23-р хороо, Богдхан уулын дархан цаазат газар нутаг Нүхтийн амны 2-р хиргисүүр (Цэрэндагва, Амгалантөгс нар, 2023) зэрэг газруудад хийжээ. Харин 14, 15, 23-р дурсгалууд нь дөрвөлжин хүрээтэй, дөрвөн буландаа чулуун байгууламжтай ба эдгээр дурсгалтай ижил дурсгалын малтлага судалгааг Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Баянзүрх уулын 1-р хиргисүүр (Амартүвшин нар, 2015), Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг Бага газрын чулууны Монголын ар, Өндөр хондын 1-р хиргисүүр (Амартүвшин нар, 2010а), 2018 онд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Чавганцын Улаан уулын 1-р хиргисүүр (Амгалантөгс нар, 2007), Улаан Уушги уулын Хамуутын амны 1-р хиргисүүр (Амгалантөгс нар, 2018) гэх мэт дурсгалуудтай гадаад болон дотоод бүтэц зохион байгуулалт, оршуулгын зан үйлээр ижил байна.

Малтан судалсан дөрвөлжин хүрээтэй 14, 15, 23-р дурсгалууд нь бусад бүс нутгийн ижил дурсгалуудтай харьцуулахад онцгойрон ялгарах зүйлгүй гадаад бүтэц, оршуулгын зан үйлээр ижил байгаа бол дугуй хүрээтэй 10, 11, 12, 13-р дурсгалууд нь гадаад бүтэц, оршуулгын зан үйлийн хувьд бусад бүс нутгийн дурсгалуудтай ижил боловч бүгд ямар нэгэн дагуул байгууламж байхгүй байгаа нь тухайн бүс нутгийн онцлог шинжийг харуулж байна. Нийт 7 хиргисүүрийн 6 дурсгалаас хүний оршуулга илэрсэн бөгөөд эдгээрийн 10, 11, 13-р дурсгалууд нь тоногдож, сүйтгэгдээгүй, илэрсэн хүний ясны хадгалалт маш сайн бараг бүтнээрээ байсан бол 12, 14, 23-р дурсгалууд нь их бага хэмжээгээр тоногдож хүний ясны ихэнх хэсэг үгүй болжээ.

Хиргисүүр-буган хөшөөний соёлынхон НТӨ XIII-VIII зуун буюу 600 орчим жилийн хугацаанд оршин тогтнохдоо газар нутгийн хувьд хойд тал нь Өвөр Байгал, өмнөд тал нь Говь, зүүн тал нь Хэнтий нуруу, баруун тийш Алтай нуруу, цаашлаад Тэнгэр уул хүртэл асар уудам нутагт өөрсдийн булш, оршуулга, тахилын байгууламжийг бүтээн цогцлоожээ (Амгалантөгс нар, 2024). Бидний малтан судалсан эдгээр дурсгалуудын холбогдох он цаг дээр дурдсан он цагийн хүрээнд хамаарах болов уу хэмээн урьдчилсан байдлаар таамаглал дэвшүүлж байна. Дурсгалуудын холбогдох үнэмлэхүй он цаг, угсаа гарал буюу генетикийн судалгаа зэрэг нарийвчилсан судалгаа цаашид хийхээр төлөвлөж байна.

Дүгнэлт

Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн нутаг “Аргал” нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд нийт 9 дурсгал малтах төлөвлөгөөтэй байсан ба малтлага судалгаа төлөвлөгөөний дагуу амжилттай явуулсан. Малтан судалсан нийт 9 дурсгалын 7 нь хиргисүүр бөгөөд эдгээрийн 10, 14, 15, 23-р дурсгал нь дөрвөлжин хүрээтэй хиргисүүр бол 11, 12, 13-р хиргисүүр нь дугуй хүрээтэй байна. Дөрвөлжин хүрээтэй хиргисүүрүүд нь бүгд тодорхой тооны дагуул байгууламжтай бол дугуй хүрээтэй хиргисүүрүүдэд дагуул байгууламж байхгүй байгаа нь ихээхэн өвөрмөц онцлогтой байна. Нийт 9 дурсгалыг дотор нь ангилбал: 09, 22 дугаар дурсгалуудыг хэдийгээр хайгуул судалгааны ажлын хүрээнд монгол булш, хүрлийн үеийн булш хэмээн тэмдэглэсэн байсан ч гэсэн бидний малтлага судалгаагаар хүний гараар бүтсэн тахил тайлгын зориулалттай чулуун байгууламж болох нь тодорхой болсон. Харин бусад дурсгал нь хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр, буган чулуун хөшөөний соёлд холбогдох дурсгалууд болох нь тодорхой байв. Малтан судалсан нийт 7 хиргисүүрийн 6 дурсгалаас хүний оршуулга илэрсэн.

Мөн 15-р дурсгалын төв дараас чулуун доороос илэрсэн хавтан чулуун дээр дүрсэлсэн хадны зураг нь хадгалалтын хувьд маш сайн бөгөөд цаашид уг чулууг хамгаалалтад авах нь зүйтэй хэмээн үзсэний дагуу “Алтгана ресурсес” ХХК нь дээрх хадны зураг бүхий чулууг хамгаалалтад авсан болно.

Хиргисүүр-буган хөшөөний соёлынхон НТӨ XIII-VIII зуун буюу 600 орчим жилийн хугацаанд оршин тогтнохдоо газар нутгийн хувьд хойд тал нь Өвөр Байгал, өмнөд тал нь Говь, зүүн тал нь Хэнтий нуруу, баруун тийш Алтай нуруу, цаашлаад Тэнгэр уул хүртэл асар уудам нутагт өөрсдийн булш, оршуулга, тахилын байгууламжийг бүтээн цогцлоожээ. Уг бүс нутагт урьд өмнө энэ үеийн дурсгалуудын малтлага судалгаа харьцангуй бага хийгдсэнээрээ онцлог бөгөөд энэхүү бүс нутагт

эрт цагаас хүн тасралтгүй оршин амьдарч байсан, оршуулгын өвөрмөц зан үйл, олон соёлын үйл явц бүрэлдэн тогтсон болохыг харуулах судалгаа болж чадсанаараа эрдэм шинжилгээний хувьд чухал ач холбогдолтой юм.

Conclusion

Archaeological excavations were successfully carried out in the “Argal” licensed area located in Ögöömör bag, Lün soum of Töv province, where a total of nine monuments had been planned for investigation. Of these nine excavated sites, seven are khirgisuur-type monuments. Among them, monuments 10, 14, 15, and 23 represent square-frame khirgisuurs, while monuments 11, 12, and 13 are circular in plan. The square-frame khirgisuurs are characterized by the presence of accompanying satellite structures, whereas the circular khirgisuurs lack such features—an observation that is particularly distinctive for this group.

Within the set of nine monuments, Sites 09 and 22 had previously been recorded during survey work as Mongol-period or Bronze Age burials. However, excavation results revealed that both are in fact anthropogenic stone structures constructed for ritual purposes rather than funerary use. The remaining sites were confirmed to belong to the Bronze Age khirgisuur tradition and the Khirgisuur-Deer Stone cultural complex. Human burials were identified in six of the seven excavated khirgisuurs.

A well-preserved petroglyph engraved on a slab beneath the central cairn of monument 15 was also discovered. In accordance with recommendations for its long-term protection, “Altgana Resources” LLC has taken measures to safeguard this engraved stone.

The Khirgisuur-Deer Stone cultural tradition flourished over an estimated 600-year span, from the 13th to the 8th centuries BCE. Throughout this period, communities created burial and ritual complexes across an extensive territory stretching from Trans-Baikal in the north to the Gobi in the south, from the Khentii range in the east to the Altai Mountains and as far as the Tian Shan in the west. Despite the region’s rich cultural landscape, systematic excavations of this cultural horizon have remained relatively limited. The present research therefore makes a significant scholarly contribution by demonstrating continuous human occupation in the area since early times, revealing distinctive mortuary practices, and providing insights into the development and interaction of multiple cultural traditions.

НОМ ЗҮЙ

Амартүвшин, Ч., Гүнчинсүрэн, Б., Эрэгзэн, Г., Эрдэнэ-очир, Н., Бадма-Оюу, Б., Өлзийбаяр, С., Батсүрэн, Б., Базаргүр, Д., Амгалантөгс, Ц.,

Лхүндэв, Г., Мандах, Д., Галдан, Г., Батдалай, Б., Очир, Б., Одмагнай, Г. “Эгийн гол түүх, археологийн дурсгалуудын авран хамгаалах судалгаа” төслийн тайлан. ШУА-ийн АХГБСХ. УБ., 2015.

Амартүвшин, Ч., Алдармөнх, П., Улаанбоомын хүрэл зэвсгийн үеийн дурсгал. *Studia Archaeologica*. Tom. IX (XXIX), fasc. 4, УБ., 2010.

Амартүвшин, Ч., Жаргалан, Б. Хүрэл зэвсгийн үеийн булшны судалгаа. *Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага газрын чулуу*. УБ., 2010а.

Амгалантөгс, Ц., Эрдэнэ, Б., Дэлгэрмаа, Л., Мандах, Д. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Арбулаг сумын нутагт ажилласан Монгол-Америкийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн 2007 оны тайлан. ШУА-ийн АХГБС. УБ., 2007.

Амгалантөгс, Ц., Эрдэнэ Б. Хөвсгөл аймгийн нутагт хийсэн археологийн хайгуул малтлага судалгаа. Монголын палеоантропологийн судалгаа. Боть II. Монгол-Солонгосын хамтарсан судалгааны тайлан. Дэжон, 2018. (монгол, солонгос хэлээр)

Амгалантөгс, Ц., Анхбаяр, Б., Болорбат Ц., Батболд, Г., Дэлгэрмаа, Л., Буян-Орших, Б., Цао Жиан эн, Сүн Гүо дүн, Цао Пэн, Цай Си. Цагаан туруут голын хүрлийн үеийн дурсгалуудын холбогдох он цагийн асуудалд. *Studia Archeologica*. Tomus XXXIX, fasc. 3, УБ., 2020: 26-38.

Амгалантөгс, Ц. “Хиргисүүрийн соёлын судалгаа” (Монгол улсын нутаг дахь дурсгалаар) Улаанбаатар, 2024.

Батсайхан, З., Амартүвшин, Ч., Содномжамц, Д., Батдалай, Б., Батзориг, Б. Төв аймгийн Лүн сумын Оорцог ууланд хийсэн археологийн судалгааны товч үр дүн. “Монголын Археологи-2018” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2019: 99-100.

Бүрэнтөгс, Г., Баяндэлгэр, Хос-Эрдэнэ, Г. Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн нутагт орших XV-019114 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайлан. МҮМГБСХ. Улаанбаатар, 2024.

Гүнчинсүрэн, Б., Базаргүр, Д., Амгалантөгс, Ц., Буянхишиг, Ц. Төв аймгийн Лүн, Баянхангай сумын зааг нутаг дахь “Булнай түшиг” ХХК-ийн “Тээг” хайгуулын талбайд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. ШУА-ийн ТАХБМТ. УБ., 2012.

Цэрэндагва, Я., Төрбат, Р., Далантай, С. Төв аймгийн Лүн сумын нутагт эртний судлалын хайгуул хийсэн тухай. “Монголын Археологи-2016” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2016: 36-39.

Эрдэнэбат, У. МУИС-ийн Археологи, антропологийн салбарын оюутны 2009 оны танилцах дадлагын тайлан. МУИС. Археологи, антропологийн тэнхим. ГБСХ. Улаанбаатар, 2009.

REFERENCES

- Amartuvshin Chunag, Gunchinsuren Byambaa, Eregzen Gelegdorj, Erdene-Ochir Nasan-Ochir, Badma-Oyu Badamkhand, Ulziibayar Sodnom, Batsuren Barangas, Bazargur Dashzeveg, Amgalantugs Tsend, Lkhundev Guunii, Mandakh Davaasuren, Galdan Ganbaatar, Batdalai Byambatseren, Ochir Battulga, Odmagnai Gansukh. "Egiin goliin tuukh, arkhaeologiin dursgaluudiin avran khamgaalakh sudalgaa" tusliin tailan [Study on the Rescue and Preservation of Historical and Archaeological Monuments of the Egiin Gol]. Ulaanbaatar, 2015.
- Amartuvshin Chunag, Aldarmunkh Purev. Ulaanboomiin khurel zevsgiin uyiin dursgal [Bronze age sites of Ulaanboom]. *Studia Archaeologica*. Tom. IX (XXIX), fasc. 4, Ulaanbaatar, 2010.
- Amartuvshin Chunag, Jargalan Burentogtokh. Khurel zevsgiin uyiin bulshnii sudalgaa. *Dundgovi aimagt khiisen arkhaeologiin sudalgaa; Baga gazriin chuluu* [Archaeological research conducted in Dundgovi province: Baga Gazryn Chuluu]. Ulaanbaatar, MAS. 2010.
- Amgalantugs Tsend, Batshatar Erdene, Delgermaa Lkhagvadorj, Mandakh Davaasuren. Khuvsgul aimgiin Burentogtokh, Arbulag sumiin nutagt ajillasan Mongol-Amerikiin arjkheologiin kheerii shinjilgeenii angii 2007 oni tailan [2007 report of the Mongolian-American joint archaeological field survey conducted in Burentogtokh and Arbulag soums of Khovsgol province]. Ulaanbaatar, MAS. 2007.
- Amgalantugs Tsend, Batshatar Erdene. Khuvsgul aimgiin nutagt khiisen arkheologiin khaiguul maltlaga sudalgaa. Mongoliin paleoanthropologiin sudalgaa. Boti II. Mongol-Solongosiin khamtarsan sudalgaani tailan [Archaeological survey excavations conducted in Khovsgol province. Research on Mongolian Paleoanthropology. Vol. II. Report of the Mongolian-Korean joint research]. Daejeon, 2018. (in Mongolian and Korean)
- Amgalantugs Tsend, Ankhbayar Batsuuri, Bolorbat Tserendorj, Batbold Gonchig, Delgermaa Lkhagvadorj, Buyan-Orshikh B, Cao Jian En, Song Guo Dong, Cao Peng, Cai Xi. Tsagaan turuut goliin khurliin uyiin dursgaluudiin kholbogdokh on tsagiin asuudald [Related chronology of the bronze age sites in the Tsagaan turuut river basin]. *Studia Archeologica*. Tomus XXXIX, fasc. 3, Ulaanbaatar, 2020: 26-38.
- Amgalantugs Tsend. *Khirigisuuriin soyoliin sudalgaa (Mongol ulsiin nutag dakhi dursgalaar), [Research on the Khirgisuur Culture" (Based on monuments in the territory of Mongolia)]*. Ulaanbaatar, 2024.
- Batsaikhan Zagd, Amartuvshin Chunag, Sodnomjamts Damchaabadgar, Batdalai Byambatseren, Batzorig B. Tuv aimgiin Lun sumiin Oortsog uuland khiisen arkhaeologiin sudalganii tovch ur dun [Brief results of archaeological research conducted on Oortsog mountain, Lun district, Tuv province]. *Mongolian Archaeology* - 2018. Ulaanbaatar, 2019: 99-100.
- Burentugs Ganbold, Bayandelger, Khos-Erdene G. Tuv aimgiin Lun sumiin Uguumur bagiin nutagt orshikh XV-019114 dugaartai khaiguuliin tusgai zovshuurliin talbai arkheologiin avran khamgaalakh khaiguul sudalganii ajliin tailan [Report on the archaeological rescue survey work of the exploration special license area No. XV-019114 located in Ogoomor, Lun, Tuv province]. Ulaanbaatar, 2024.
- Gunchinsuren Byambaa, Bazargur Dashzeveg, Amgalantugs Tsend, Tserenkhand Buyankhishig. Tuv aimgiin Lun, Bayankhangai sumiin zaag nutag dahi Bulnai Tushig Khyazgaarlagdmal khariutslagatai companiin Teeg khaiguuliin talbaid khiisen arkheologiin khaiguul sudalganii tailan [Report on the archaeological survey conducted at the "Teeg" exploration site of "Bulnai Tushig" LLC located in the border area of Lun and Bayankhangai, Tuv province]. Ulaanbaatar, 2012.
- Tserendagva Yadmaa, Turbat R., Dalantai Sarantuya. Tuv aimgiin Lun soumiin nutagt ertnii sudlaliin khaiguul khiisen tukhai [On the archaeological survey conducted in the territory of Lun, Tuv province]. *Mongolian Archaeology* - 2016. Ulaanbaatar., 2016: 36-39.
- Erdenebat Ulambayar. MUIS-Arkheologi anthropologiin salbariin oyutni 2009 onii taniltsakh dadlagiin tailan [Field practice report of students from the Archaeology and Anthropology Department, National University of Mongolia]. NUM, Department of Archaeology and Anthropology. Ulaanbaatar, 2009.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>